# 4.1.1. Сургуулийн сургалтын төлөвлөгөөний сонгон судлах хичээл бүртгэх

### 4.1.1. Сургуулийн сургалтын төлөвлөгөөний сонгон судлах хичээл бүртгэх

**<u>Анхаарах нь:</u>**

- *Заавал судлах хичээл нэмж үүсгэх шаардлага гарвал системийн тусламжийн утас руу ярих, и-мэйл илгээх*

Хичээлийн жагсаалтын баруун дээд буланд байрлах “Шинэ хичээл” товчин дээр даран хичээл нэмэх цонх руу шилжинэ

.




**<u>1.Хичээлийн ангилал</u>** талбар дээр **<u>сонгон судлах хичээл</u>** төрлийг сонгон 1 хичээл үүсгэе.

•***<u>Салбар, бүрэлдэхүүн</u>*** талбарт сургууль сонгоно. Ихэнх сургуулийн хувьд салбар байдаггүй тул ганц сонголттой байна

•***<u>Хөтөлбөрийн төрөл</u>*** талбарт сургуулийн хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдийн жагсаалтаас сонгоно. Би 7-р ангид хичээл нэмэх бол ЕБС-Суурь боловсрол-г сонгоно гэсэн үг.

•***<u>Суралцагчийн түвшин</u>*** талбарт дээр сонгосон хөтөлбөрт хамаарах ангийн жагсаалтаас сонгоно. Би 7-р ангид хичээл нэмэх бол 7-р анги-г сонгоно гэсэн үг.

•***<u>Хичээлийн ангилал</u>*** талбарт тухайн сургуулийн хэв шинж болон бүтцээс хамааран сонгон судалж болох хичээлийн ангиллууд харагдана. Жишээлбэл Би 7-р ангид тусгай хичээл нэмэх тусгай хичээлийн ангиллыг сонгоно гэсэн үг.

*Хэрвээ тухайн сургууль тусгай зөвшөөрлийн хүрээнд гүнзгийрүүлсэн,төрөлжсөн хичээл заадаг гүнзгийрүүлсэн, төрөлжсөн хичээлийн ангилал харагдан, сонгох боломжтой.*

•***<u>Хичээлийн индекс</u>*** талбар автоматаар бөглөгдөн харагдана.

•***<u>Хичээлийн нэр</u>*** талбар автоматаар бөглөгдөн харагдана.

